

ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Р.БАДМААДОРЖИЙН
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
НЭГ.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт							
"Хүн төвт хөгжлийн хөтөлбөр"-3							
1	Зорилт1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах	Төсөлд оруулах нэмэлт өөрчлөлтийн саналыг газрын болон харьяа байгууллагын албан хаагчдаас авч саналыг нэгтгэх	1997 онд батлагдсан тус хуулинд ус цаг уурчдын нийгмийн асуудал болон бусад хууль, тогтоол шийдвэрүүдтэй уялдаагүй	Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж, томоохон өөрчлөлт хийхээр шинэчилсэн байна.	Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлыг 5 багц болгон хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагыг хангасан "Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай" (УЦУОХШТХ) шинэчилсэн найруулагатай хуулийн төсөл боловсруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж байна. Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын болон Хуулийн төслийг боловсруулах зөвлөх үйлчилгээг мэргэжлийн баг, байгууллагаар гүйцэтгүүлэн хүлээн авч тус газрын болон Яамны ажлын хэсгээр	I-IV улирал	80%

					хэлэлцүүлэг хийгдсэн. Хуулийн шинэчлэлд нийгмийн асуудлыг хуульчилж оруулсан нэг зүйл багц болгон оруулсан.		
2.	<p>Арга хэмжээ:1.1 Салбарын холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, сайд, газрын даргын тушаалын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, тайлан мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагад цаг хугацаанд хүргүүлэх;</p>	Хэрэгжилтийн хувь	Судалгаа, тайлан мэдээг хугацаандаа гаргаж, 100 хувь бүрэн хүргэгдсэн.	УЦУОХШ-ний салбарын хамаарал бүхий хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, тайлан мэдээг тогтоосон хугацаанд гаргасан байна.	Засгийн газрын хуралдааны цахим системд Засгийн газрын тогтоол-8, тэмдэглэл-14, Ерөнхий сайдын захирамж-2 албан даалгавар-2 нийт 28 шийдвэрийг газрын дарга болон нэгжийн дарга нарт танилцуулан цохогдсон нэгжийн даргад илгээн хариу тухай бүр хүргүүлсэн. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлан болон үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөөгний биелэлт-2, хууль тогтоомж тогтоол шийдвэрийн тайлан 4, санал 2, онцлох ажлын мэдээ-1, нийт 9 удаагийн биелэлт тайлан мэдээ, БОУАӨЯ-ны төлөвлөгөө болон байгууллагатай холбоотой биелэлтийг хариуцсан нэгжийн даргаас авч нэгтгэн яамны тайлан төлөвлөлт хариуцсан мэргэжилтэнд тухай бүр илгээж ажилласан.	I-IV улирал	100% ✓
3	<p>Арга хэмжээ: 1.2 Салбарын болон байгууллагын төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлагын манлайлалыг хангаж, чадавхийг дээшлүүлэх, төрийн албаны стандартыг хангах</p>	Салбарын хэмжээнд хүний нөөцийн удирдлагын манлайлалын талаар хэрэгжиж байгаа журам, дүрэм шинэчлэгдсэн байна.	Байгууллагын дотоод журам 2024 онд шинэчлэн батлагдсан.	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой журам боловсруулах, шинэчлэн гаргасан байна.	Цаг уур, орчны шинжилгээний газрын Жижүүрийн дагаж мөрдөх журам, Байр ашиглалтын журам, Спорт заал ашиглах журам, Албан хэрэг хөтөлөлтийн журам, Баримт шалгах комиссын дүрэм, Байгууллагын архивын нийтлэг үйл ажиллагааны журам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийтлэг журам, зааварчилгааг хянан, боловсруулж батлуулсан. Байгууллагын дотоод журам шинэчлэн батлуулахаар албан хаагчдаас санал авч нэгтгэн	I-IV улирал	90% 80 Бүтээгч

*Овоо Яаруу
Тайлан
Бүтээгч.*

					боловсруулж, хамт олноороо хэлэлцүүлэн батлуулахаар хүлээгдэж байна.		
ХОЁР. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6.2-р заалт, "Хүн төвт хөгжлийн хөтөлбөр"- нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд							
1	Зорилт 2. "Салбарын хүний нөөцийн тулгамдаад байгаа сул орон тоог зарлан бүрэн нөхөх	Хүний нөөцийн судалгааг гаргаж, сул орон тоог нөхөх тоо	4 албан тушаалд сул орон тоо нөхөгдсөн.	Нөхөгдсөн тоо	Төрийн үйлчилгээний 8 албан хаагч өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн. Газрын бүтэц орон тоо өөрчлөгдсөнтэй холбоотой 4 албан хаагч ТЗ албан тушаалд шилжсэн. 2 албан хаагчийн хүрээлэнгийн, 1 албан хаагчийг Хан Хэнтий ТХЗГ-ийн мэдэлд шилжүүлсэн ба 2 албан хаагч тэтгэвэр тогтоолгож, чөлөөлөгдсөн. Урт хугацааны чөлөө 2 албан хаагч авсан. Одоо ТҮ-ний 2 сул орон тоо, 1 эзгүй албан тушаал байна. Төрийн үйлчилгээний албан тушаалд 11 албан хаагч ажилд орсон. Урт хугацааны чөлөөнөөс 1 албан хаагч ажилдаа орсон. Төрийн үйлчилгээний сул орон тооны зарыг 5 удаа цахим сайтад байршуулсан.	I-IV улирал	90%
2	Арга хэмжээ:2.1 Шилэн дансны хуулийн хэрэгжүүлэх, санхүү, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байх ажлыг зохион байгуулах	Хуулийн дагуу хугацаандаа байршуулах хэрэгжилт хувь	99.2 хувь	99.3 хувь	"Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт"- 2023.12-2024.05 сарын нийт 12 удаагийн мэдээллийг хугацаанд нь хийж зохион байгуулсан. "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл", "Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт"- байхгүй гэсэн тайланг хугацаанд нь 8 дугаар сар хүртэл хийж гүйцэтгэж 9 дүгээр	I-IV улирал	100%

					сараас хяналт, дотоод аудитын хэлтсийн албан хаагчид шилжүүлсэн. Шилэн дансны хуулийн хэрэгжүүлэх, санхүү, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байх ажлыг зохион байгуулах ажлын чиг үүрэг нь хяналт, дотоод аудитын хэлтэст шилжүүлсэн.		
3	Арга хэмжээ:2.2 Төрийн албаны тухай хууль тогтоомж, тогтоол шийдвэр, стандартын хэрэгжилтийг хангаж, харьяа 26 байгууллага, газрын нэгжийн болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнах, урамшуулах	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг тогтоол, журмын дагуу батлуулж, биелэлтийг тайлагнасан тоо	26 байгууллага, 6 хэлтэс, 68 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан, хяналт, үнэлэлт өгч урамшуулал олгосон.	26 байгууллага, 6 хэлтэс, 68 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан, үнэлнэ.	Газрын даргын 2025.06.25-ны А/129 дүгээр тушаалаар 67 албан хаагчид 1, 2 дугаар улирлын үр дүнгийн урамшуулалд нийт 91,535,000төгрөг олгох тухай тушаалыг батлуулсан. 2025.12.05-ны А/277 дугаар тушаалаар Тус газрын албан хаагчдын 2025 оны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, хянаж баталгаажуулах, мэдээлэх чиг үүрэг бүхий Үнэлгээний багийг байгуулсан. Харьяа байгууллагуудын 2025 оны тайланг мөн Газрын 2025 оны жилийн тайланг газар, нэгж, харьяа байгууллагаас авч нэгтгэж Хяналт дотоод аудитын хэлтэст хүргүүлсэн.	VI, XII сард	100% ✓
4	Арга хэмжээ:2.3 Салбарын албан хаагчдыг шагнал урамшуулал олгох ажлыг зохион байгуулах	шагнал урамшуулалд хамрагдсан хүний тоо	Нийт төрийн болон яам, газрын шагналаар 559 албан хаагч шагнагдсан	Төрийн дээд болон яамны шагналаар шагнагдсан албан хаагчийн тоо	Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын нийт 69 албан хаагчийг Төрийн дээд одон медальд, 7 албан хаагчийг Засгийн газрын шагналд, 9 албан хаагчийг БОУАӨЯ-ны жуух бичигт тодорхойлж, холбогдох журмын дагуу материалыг бүрдүүлж, БОУАӨЯ-нд хүргүүлсэн. Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын нийт 46 албан хаагчийг Төрийн дээд одон медалиар, 6 албан хаагчийг Засгийн газрын шагналаар, 9 албан хаагчийг БОУАӨЯ-ны жуух бичгээр, ЦУОШГ-ын жуух бичгээр 5 албан хаагч шагнагдсан.	I-IV улирал	100% ✓

5	Арга хэмжээ:2.4 Жендэрийн асуудалтай холбоотой судалгаа, тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргаж хүргүүлэх.	Хугацаанд хүргүүлсэн тайлангын тоо	-	Хугацаандаа хүргэгдсэн байна.	Үндэсний статистикийн хорооноос жил бүр явуулдаг байгууллагын жендэрийн тайланг 2025 оны 01 дүгээр сарынд 10-нд цахимаар илгээсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ба эрхийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт хэлэлцүүлэгт оролцсон.	I-IV улирал	90%
6	Арга хэмжээ:2.5 Салбарын албан хаагчдыг мэргэжлийн түвшинг үнэлэх, зэрэг дэв, олгох ажлыг зохион байгуулах	Зэрэг дэв олгох, хамрагдсан хүний тоо	Мэргэшлийн зэрэг 214 албан хаагчдад шинээр болон ахиулан олгосон.	Мэргэшлийн зэрэг албан хаагчдад шинээр олгосон тоо	2025.01.15-ны 01/29 дүгээр албан бичгээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны дэргэдэх төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд тус газрын төрийн захиргааны 14 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулах, 5 албан хаагчийн зэрэг дэвийг шинээр олгохоор хүсэлтийг явуулсан. БОУАӨ-ын Сайдын 2025 оны А/71 дүгээр тушаал, газрын даргын 2025.02.17-ны А21 дүгээр тушаалаар 19 албан хаагчийн зэрэг дэвийн ахиулж болон шинээр олгосон. БОУАӨС-ын 2025 оны А/591, тус газрын даргын 2025.06.17-ны А/117 дугаар тушаалаар 22 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулж, 1 шинээр олгосон. Мэргэшлийн зэргийн шалгалтад 78 албан хаагчийг хамруулж, 5 удаагийн шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтад хамрагдсан албан хаагчдаас 18 албан хаагч мэргэшлийн зэргээ ахиулж, 20 албан хаагч шинээр мэргэшлийн зэрэг авсан.	I-IV улирал	100%
7	Арга хэмжээ:2.6 Төрийн албаны хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд байгууллагын зорилт, чиг үүргийг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх хүний нөөцийг бүрдүүлэх, холбогдох тушаал	Холбогдох хуулийн дагуу тушаал шийдвэр, тайлан мэдээг хугацаандаа гүйцэтгэсэн тоо		Холбогдох хуулийн дагуу тушаал шийдвэр, тайлан мэдээг гүйцэтгэсэн тайлангийн тоо	Хүний нөөцтэй холбоотой 126 (Б тушаалын 100 хувь), бүтэц, зохион байгуулалт, цалин хөлстэй холбоотой 52 (А тушаалын 18.2 хувь) боловсруулан холбогдох дарга, албан хаагч нараар хянуулан баталгаажуулан гаргаж, холбогдох	I-IV улирал	100%

	<p>шийдвэрийн төсөл боловсруулах, хүний нөөцтэй холбоотой судалгаа, тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргаж хүргүүлэх</p>		<p>147 үзүүлэлтээр 7 байгууллагад тайлан хүргүүлсэн.</p>		<p>албан хаагч нарт мэдээллийг хүргэж ажилласан. -Салбарын батлагдсан орон тоо, одоо ажиллаж байгаа албан хаагчийн тоо, сул орон тооны судалгаа -Сонгон шалгаруулалтгүйгээр түр томилогдсон албан тушаалтны мэдээлэл судалгаа -Ус цаг уур, орчны шинжилгээний салбарт ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдын тоо, квотын хэрэгжилт -Сул орон тоо болон түр орлон гүйцэтгэгч нарын судалгаа -Нэгжийн дарга нарын судалгаа, ЦУОШГ-ын болон харьяа дарга нарын сул орон тоо, түр орлон гүйцэтгэгч нарын судалгаа -Салбарын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үйл ажиллагааны тайлан -Салбарын хүний нөөцийн боловсролын судалгааг авч нэгтгэж БОУАӨЯаманд хүргүүлсэн.</p>		
8	<p>Арга хэмжээ.2.7 Цаг уур, орчны шинжилгээний газрын болон харьяа байгууллагын дарга, захирал нарын хувийн хэргийн бүрдүүлэлтийг хийх, баяжуулалт хийх Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн системд Цаг уур, орчны шинжилгээний газрын албан хаагчдын мэдээллийг тухай бүрд нь шинэчлэн оруулах</p>	<p>Хувийн хэргийн бүрдүүлэлт хийгдсэн албан хаагчдийн тоо</p>	<p>25 харьяа байгууллагын төсвийн шууд захирагч, газрын 67 албан хаагчийн хувийн хэрэг бүрдсэн.</p>	<p>2022 оны 600 дугаар тогтоолын хавсралтаар шинээр бүрдүүлсэн албан хаагчийн тоо</p>	<p>2025 онд тус газрын бүтэц 2 удаа шинэчлэгдсэнтэй холбогдуулан тухай бүрт нь бүтэц, албан тушаал, албан хаагчийн мэдээллийг шинэчилэн баталгаажуулсан. Шинээр орсон албан хаагчдыг тухай бүрт системд бүртгэн мэдээллийг оруулж, мөн ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдыг идэвхгүй төлөвт бүртгэсэн. Албан хаагчдын цалин хөлс, бусад мэдээллийг тухай бүрт өөрчилж, тушаал шийдвэрийг оруулж ажилласан. 2025 онд Ажлаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 11 албан хаагч, шилжин</p>	<p>I-IV улирал</p>	<p>100%</p>

					ажиллаж байгаа 5 албан хаагч нарт хувийн хэргийг буцаан өгсөн. Албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг бүрдүүлж 2024, 2025 оны хагас жилийн үнэлгээ, ТҮ албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, тушаал шийдвэрийг хувийн хэргийн бүрдүүлэлтийг хийн ажилласан.		
9	Арга хэмжээ:2.8. Байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх	Контентийн тоо	1	2	Агентлагын Цаг уур, орчны шинжилгээний газар гэсэн facebook хаяган дээр Ой, байгалийн ургамал, амьтан, газрын хэвлий, ус, рашаан ашиглалт, хаягдал ус, хог хаягдал, химийн бодис зэрэг байгаль орчинд шууд буюу шууд бусаар хохирол учруулж болзошгүй нөхцөл байдал үүссэн талаарх иргэд олон нийтийн мэдээллийг 117 тусгай дугаарын утсанд дээр, Авлигын талаарх гомдол мэдээллийг АТГ-ын 110 дугаарын утсаар хүлээн авах талаар зурган хэлбэрээ байршуулсан.	II-IV улирал	100%
10	Арга хэмжээ:2.9 Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг шинэчлэн батлуулж, тухайн жилийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх	Шинэчлэн батлуулсан төлөвлөгөөний хэрэгжилт 100%	2020-2024 оны нийгмийн баталгааг хангах, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг	2025-2028 оны нийгмийн баталгааг хангах, сургалтын хөтөлбөрийг шинэчлэн батлуулсан байна.	Газрын даргын 2025.04.29-ны А/62 дугаар тушаалаар Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр боловсруулж, өнөөгийн байдлын судалгааг авч түүнд дүн шинжилгээ хийж, салбарын нийгмийн баталгааны 2025-2028 оны хөтөлбөрийг газрын даргын 2025.07.07-ны А/147 тушаалаар батлуулсан. Тус газрын болон харьяа байгууллагын мэргэжлийн албан хаагчдын сургалтын хэрэгцээ шаардлага, санал хүсэлтийг хүлээн авч судалгаа хийж сургалтын	I-IV улирал	100%

			100 хувь биелүүлсэн.		төлөвлөгөөг боловсруулж, газрын даргаар батлуулж, 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хамтаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хүргүүлсэн.		
11	<p>Арга хэмжээ:2.10 Газар, аймаг, хотын УЦУОШТөв болон харьяа байгууллагуудын албан хаагчдын гадаад, дотоод сургалт, семинарт оролцох, төрийн албан хаагчдийг мэргэшүүлэх сургалтуудад хамрагдах ажлыг зохион байгуулах, арга зүйн туслалцаа үзүүлэх</p>	Сургалтад оролцсон албан хаагчийн тоо	Албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах зорилгоор гадаадын 15 сургалтад 21, дотоодын 13 сургалтад 31, УА сургалтад 15 албан хаагчид хамрагдсан байна.	Аймаг, нийслэлийн төвийн дарга нарыг УА-ын онлайн ангид сургасан байна.	<p>Газрын даргын баталсан 2025 оны "Сургалтын төлөвлөгөө"-ний дагуу 8 төрлийн сургалтад тус газраас харьяа байгууллагын 100 гаруй давхардсан тооны албан хаагчдад сургалт зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/870 дугаар албан бичгээр 2025 жилийн сургалтын тайланг гаргаж Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Мөн тус газрын 2025 оны 01/32, 01/204, 01/614 дүгээр албан бичгүүдээр Удирдлагын академийн Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 3 албан хаагч, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 3 албан хаагч тус тус хамрагдсан.</p> <p>Газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/254 дүгээр тушаалаар Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын "Сургалтын хөтөлбөр" батлуулсан.</p>	I-IV улирал	100%

*Захирагчийн
Зорилго өргөө
түвшин бүрэн*

12	<p>Арга хэмжээ:2.11 Газрын даргын өдөр тутмын ажилд туслах, мэдээллээр хангах, гадаад, дотоод уулзалтыг зохион байгуулан зохицуулах, газрын тамга, тэмдэг түших ажлыг гүйцэтгэх, газрын даргатай байгуулсан гэрээг бүртгэх хадгалах, хяналт тавих</p>	<p>Газрын даргын туслахын үүргийг гүйцэтгэж, журмын дагуу тамга тэмдэг хэрэглэсэн байх</p>	<p>Газрын даргын өдөр тутмын ажилд туслаж, гадаад, дотоод уулзалтыг зохион байгуулан зохицуулж, газрын тамга, тэмдэг түших ажлыг гүйцэтгэж, газрын даргатай байгуулсан гэрээг бүртгэн хадгалж, хяналт тавьж ажилласан.</p>	<p>Төрийн захиргааны байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж, ажлаа тайлагнасан байна.</p>	<p>Газрын даргын 2025 оны А/159 дүгээр тушаалаар Тамга, тэмдэг түших албан хаагчийг 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилж түшүүлсэн тул тухайн албан хаагчид шилжүүлэн өгсөн. Газрын даргын туслахын ажил үүргийг гүйцэтгэж, гадаадын зочид төлөөлөгчид болон бусад уулзалт, хурлын цагийн хуваарийг зохицуулж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэж ажилласан.</p> <p><i>Хэвтсний Кррийн Өмнөөс Тайлагнах</i></p>	<p>I-IV улирал</p>	<p>100% 80</p>
13	<p>Арга хэмжээ:2.12 "Архивын тухай хууль, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн талаар гарсан Засгийн газрын тогтоол болон баримт бичгийн стандарт, заавар журмын дагуу архивын болон албан хэрэг хөтлөлтийн ажлыг эрхлэн явуулах стандартыг чанд мөрдөн ажиллаж, хадгалалт хамгаалалт үйлчилгээг хариуцах</p>	<p>Архивын хадгаламжийн нэгжийн бүртгэлийн тоо</p>	<p>Байнга - 42хн 70 жил - 6хн Түр -69хн</p>	<p>Байнга – 43 хн 70 жил – 6 хн Түр - 70 хн</p>	<p>Байнга хадгалах хадгаламжид 27 хн, түр хадгалах 89 хн, 70жил хадгалах 6хн буюу нийт 122 хадгаламжийг стандартын дагуу үдэж, хавтаслан хадгаламжийн сан, Газрын даргын А тушаал 0.238 GB, 660 файл ба Б тушаал нь 0.058GB, 158 файлын нөөц хувийг Hard-д дискенд хуулан баяжилт хийсэн.</p>	<p>I-IV улирал</p>	<p>100% 80</p> <p><i>Бэлтгэсэн Хуулийн хэргийн Хамтын үйлчилгээ Фонд ТНОУ Эмгэгчид</i></p>
14	<p>Арга хэмжээ:2.13 Баримтаар хэрэглэгчдэд үйлчлэх, Баримтын хадгалалт, стандарт нөхцлийг хангахад ариутгал, цэвэрлэгээ хийж, өрөөний ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлд хяналт тавих</p>	<p>Хэрэглэгчдэд үйлчлэх, цэвэрлэгээ, ариутгалын тоо</p>	<p>Нийт 148 албан хаагчдад 591 баримтаар үйлчилсэн. Өрөөний ариутгал 2, цэвэрлэгээ 52, тем, чийгийг 57 удаа хэмжсэн.</p>	<p>Хэрэглэгчдэд шуурхай үйлчлэх, баримтын өрөөний цэвэрлэгээ, ариутгал сайжирсан байна.</p>	<p>Дотоод ажлын хэрэгцээнд ашиглуулахаар олгосон баримтын бүртгэлийг үйлдэж нийт 16 хүнд давхардсан тоогоор 617 баримтыг дотоод ажлын хэрэгцээнд ашиглуулан, бүртгэл үйлдэж үйлчилсэн. Архивын баримтын хадгалалт хамгаалалтын ажлыг зааврын дагуу мэргэжлийн түвшинд хийх архивын баримтын өрөөний цэвэрлэгээг нийт 54 удаа, их цэвэрлэгээг нийт 6 удаа. эрүүл ахуйн нөхцөл, гэрэл, дулаан,</p>	<p>I-IV улирал</p>	<p>100%</p>

					чийгийг нийт 57 удаа хэмжиж, температур, чийг нь стандартын түвшинд хүрэхгүй тохиолдолд авах арга хэмжээг тухай бүрд нь авч ажилласан. /Жишээ нь 5-6 дугаар сард хадгаламжийн сангийн өрөөний чийг бага түвшинд хүрч байгаа тул өрөөнд савтай ус байршуулах, шалыг өдөрт 3-н удаа чийгшүүлэн ажилласан.		
15	Арга хэмжээ:2.14 Төрийн болон албаны нууцыг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтийг хангах, нууц албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулж хэрэгжүүлэх	Холбогдох хууль, журам хэрэгжсэн хувь	Төрийн болон албаны нууцыг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтийг хангах, нууц албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулж хэрэгжүүлэн ажилласан.	Нууцлалын зэрэгтэй материалыг стандартын дагуу хөтлөнө.	Төрийн болон албаны нууцыг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтийг хангах, нууц албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулж хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус газарт 2025 онд төрийн болон албаны нууцтай холбоотой 4 албан бичиг ирснийг холбогдох мэргэжилтэнд шилжүүлсэн. Мөн төрийн болон албаны нууцтай 3 албан бичиг боловсруулж хүргүүлсэн.	I-IV улирал	100%
16	Арга хэмжээ:2.15 Байгууллагын бичиг баримтыг стандартын дагуу хөтлөн явуулах, албан хэрэг хөтлөлтийн шатанд баримт бичгийн эргэлт, урсгал эмх цэгц, бүрдэл, хадгалалт, ашиглалтыг сайжруулах, үйл ажиллагааны тасралтгүй, шуурхай байдлыг хангаж ажиллах, ирсэн, явуулсан бичгүүдийг стандартын дагуу эсэхэд хяналт тавих, хүлээн авч, ангилан бүртгэж e-mongolia төрийн үйлчилгээний системд бүртгэн шийдвэрлэлт, үр дүнг тайлагнах	Стандартыг хангаж, албан бичигт хугацаанд нь хариуг өгч, тайлагнасан тоо	Газрын даргын 336 А тушаал, 133 Б тушаал, 1127 явсан албан бичиг, 1110 албан бичиг, 204 өргөдөл ирснийг стандартын дагуу e-mongolia төрийн үйлчилгээний системд бүртгэсэн.	Стандартыг хангаж хугацаанд нь бүртгэсэн тоо	Газрын даргын 274А тушаал, 125Б тушаал гарсан бөгөөд 883 албан бичиг явуулсан бөгөөд явуулсан албан бичгүүдийг стандартын дагуу хэвлэмэл хуудсанд гарган дугаарлаж, тухайн холбогдох газар луу илгээн, egr.e-mongolia системд 1112 ирсэн бичгийн бүртгэн оруулж, баримт бичгийн бүртгэлийн дэвтэрт бүртгэсэн. Архивын ерөнхий газраар А4 хэвлэмэл хуудас-200ш, А5 хэвлэмэл хуудас-500ш, тушаал хэвлэмэл хуудас-200ш тодорхойлолт хэвлэмэл хуудас-200ш захиалга өгч хэвлүүлэн дугаарласан. Үндэсний бичгийн бланк хэвлүүлэхээр Архивын ерөнхий газраас зөвшөөрөл авч батлуулж хэвлүүлэн ашиглаж байна.	I-IV улирал	100%

					<p>Байгаль орчин хэмжилзүйн төв лаборатори, Ус цаг уур, судалгаа мэдээллийн хүрээлэн, Улаанбаатар хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Үндэсний бичгийн хэвлэмэл хуудсыг батлуулж хэвлүүлэв.</p> <p>ЦУОШГ-Т 237, харьяа 4 байгууллагад нийт 245 өргөдөл гомдол ирснээс шийдвэрлэлт нь 100 хувь хариу өгсөн байна. Өргөдөл гомдлын тайланг 2024 оны 01/02 дугаар албан бичгээр 2024 оны жилийн эцсийн тайланг, 01/181 дүгээр албан бичгээр 1 дүгээр дүгээр улирлын, 01/443 дугаар албан бичгээр хагас жилийн, 01/682 дугаар албан бичгээр 3 дугаар улирлын тайланг тус тус гаргаж Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хүргүүлсэн.</p>		
ГУРАВ. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт							
1.	<p>Зорилт3. Байгууллагын архивт хадгалагдаж байгаа 2010-2017 оны түр хадгалах баримтад цахимжуулалт хийх</p>	<p>Цахим хувь үүсгэж хадгалсан баримтын файлын хэмжээ</p>	<p>2010-2015 оны 6 жилийн байнга хадгалах баримтыг сканердаж 59 фолдор 5.84 GB хэмжээтэй баримтыг цахимжуулсан.</p>	<p>Цахимжилт хийгдсэн байна.</p>	<p>Архивын ерөнхий газар хөмрөг үүсгэгч байнга хадгалах баримтыг цахимжуулдаг эрэл хайлтын GAS-программыг шинээр нэврүүлж байгаа тул тус газар нь 2026 оны эхний улиралд ашиглахаар төлөвлөгдөж байгаа тул энэ онд 2010-2017 оны түр хадгалах баримтыг цахимжуулахгүйгээр түр зогсоож байнга хадгалах 2016-2020 оны цаасан баримтыг цахимжуулсан. Үүнд:</p> <p>2016 оны 0.616GB 2017 оны 0.581GB 2018 оны 0.820GB 2019 оны 3.18 GB 2020 оны 1.34 GB Нийт 6.537GB файлыг цахимжуулсан. /хавсралтаар зургыг хавсаргав/</p>	<p>I-IV улирал</p>	<p>100%</p>

2	<p>Арга хэмжээ3.1 Газрын үйл ажиллагаанд ISO9001 чанарын менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлж, хэрэгжилтийг хангах</p>	<p>Газрын үйл ажиллагаанд ISO9001 стандартыг нэвтрүүлсэн хэрэгжилтийн хувь</p>	-	<p>Газрын үйл ажиллагаанд ISO9001 стандартыг нэвтрүүлсэн байна.</p>	<p>Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны А/20 дугаар тушаалаар шинэчлэн томилогдсон ажлын хэсэг нь ОУ-ын Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлыг Газрын даргын тушаалаар батлагдсан ажлын төлөвлөгөөний дагуу ажил хийгдэж байна. -Зөрүүгийн шинжилгээ -Чанарын удирдлагын тогтолцооны стандарт -Байгууллагын төлөв байдлыг тодорхойлох -Баримтжуулсан мэдээлэл -Бодлого, зорилго, зорилт тодорхойлох -Процесс зураглал -Хууль тогтоомж болон бусад шаардлагыг тодорхойлох, нийцтэй байдлын үнэлгээ хийх -Үйл ажиллагааны эрсдэл боломжийг тодорхойлох зэрэг ажлыг ажлын хэсгийн болон алан хаагчдын хамтаар хийж гүйцэтгэсэн.</p>	I-IV улирал	100%
3	<p>Арга хэмжээ:3.2 Байгууллага болон салбарын хэмжээнд мөрдөж ажиллаж байгаа хууль, тогтоомж, дүрэм, журам бусад шийдвэрийг хэрэгжүүлэх болон зохион байгуулж буй ажилд идэвхтэй санаачлагатай ажиллах</p>	<p>Идэвхтэй санаачлагатай ажиллах хувь</p>	-	<p>Хэлтсийн албан хаагчид байгууллагаас зохион байгуулж буй ажилд идэвх санаачлагатай ажилласан байна.</p>	<p>Байр ашиглалтын журам, спорт заал ашиглах журам, автомашин ашиглалтын журам зэрэг журмын төсөл боловсруулсан ба холбогдох албан хаагчид болон хэлтсийн дарга нараар хянуулан газрын даргад хүргүүлсэн. 2025 оны 5 дугаар сарын 10-ны өдөр тэрбум тод тарих ажиллагаанд нийт 45 албан хаагчийг хамруулан 300 гаруй мод тарих ажлыг зохион байгуулсан. Усны ажиглагч, байгаль орчны лаборотарын хүнд нөхцөлд ажиллаж байгаа албан хаагчдын ажлын байрны хүнд нөхцлийн хэмжилт шинжилгээг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл</p>	I-IV улирал	100%

1.2 - Тэмцэ
Тайлбар

					<p>ахуйн төвөөр хийлгүүлэхээр БОУАӨЯ-тай хамтран ажиллаж байна. 2025 оны 10 дугаар сарын 11-ний өдөр болох "Бүх нийтийн мод тарих өдөр" арга хэмжээг Тэрэлжид зохион байгуулах ба нийт 49 албан хаагчид оролцсон.</p>	
--	--	--	--	--	---	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн бэлтгэл ажил хангах, ажлын төлөвлөгөө батлуулах	Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн бэлтгэл ажил хангах ажлын хүрээнд ЦУОШГ-ын даргын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/188 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан төлөвлөгөө гарган батлуулсан ба харьяа 4 байгууллагуудад архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын талаар шалган туслах үзлэг явуулах удирдамжийг газрын даргаар баталгаажуулан, эхний үзлэгийг хийж, арга зүйгээр ханган ажиллаж байна.	IX.4	100%
2	УЦУОСМХүрээлэнгээс гаргаж буй бүтээгдэхүүн нь хяналтын тодорхой үе шаттайгаар боловсруулагдаж, холбогдох шат шатны удирдах албан тушаалтнуудаар хянагдан, баталгаажсаны үндсэн дээр олон нийтэд мэдээлж, зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага тооцох талаар журамлах	УЦУОСМХүрээлэнгээс гаргаж буй бүтээгдэхүүн нь хяналтын тодорхой үе шаттайгаар боловсруулагдаж, холбогдох шат шатны удирдах албан тушаалтнуудаар хянагдан, баталгаажсаны дараа олон нийтэд мэдээлэх журмыг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг байгуулагдан ажиллаж 11 дүгээр сараас эхлэн мөрдөж ажиллах журмыг боловсруулсан.	IX.4	100%
3	Харьяа байгууллагуудад албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахад хяналт тавьж, зөвлөмж хүргүүлж байх	2025 оны 9 дүгээр сарын 03-ны өдөр Цаг уур, орчны шинжилгээний салбарын харьяа байгууллагын бүтэц, орон тоо шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах зөвлөмжийг хүргүүлсэн.	IX.4	100%
4	Улаанбаатар хотын УЦУОШТ-ийн хашаан дахь газрыг албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд хэрхэн ашиглаж болох талаар санал танилцуулах	Улаанбаатар хотын УЦУОШТ-ийн дарга Идэрчулуунтай холбогдсон. Тухайн газрын ашиглагдаагүй талбайн хэмжээ болон дэд бүтцийг судлаж үүний дараа албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдэхээр холбогдох газрын зураглал, байршлын мэдээллийг авсан.	IX.4	100%

5	Дархан-Уул аймаг дахь Хөдөө аж ахуй их сургууль, МУИС-ийн Дорнод аймаг дахь салбар сургуулийн оюутнуудад мэргэжлийн дадлага хийх нөхцөл боломжийг бүрдүүлэх /НЦУТ, УМХ/	Дархан-Уул аймаг дахь ХААИС-ийн цаг уурын тэнхимтэй холбогдож УМХэлтэс. НЦУТ дээр эхний ээлжид 4 дүгээр ангийн 2-3 оюутан, аймгийн УЦУОШТөв дээр 15 оюутныг мэргэжлийн дадлага хийлгэхээр ярилцсан. Мэргэжлийн зөвлөлийн багш нартайгаа хуралдаад эргээд холбогдохоор тохиролцсон. МУИС-ийн Дорнод аймаг дахь салбар сургуулийн цаг уурын тэнхим нь одоогоор цаг уурын төв дээрээ ажиллаж буй 4 албан хаагч сурч байгаа учраас мэргэжлийн дадлага шаардлагагүй гэсэн хариу өгсөн.	IX.4	100%
6	Байгууллагын дайчилгааны төлөвлөгөө шинэчлэх	Байгууллагын гамшгийн эрсдэлийн төлөвлөгөө боловсруулагдаж батлуулсан.	IX.4	100%
7	Салбарын хэмжээнд бүтцийн өөрчлөлтөд орсон албан хаагчдын судалгааг мэргэжил, ажлын туршилгаар ангилж танилцуулах	Салбарын хэмжээнд бүтцийн өөрчлөлтөд орсон албан хаагчдын судалгааг төвүүдээс авч бүтцийн орон тооны тушаал гарсан.	IX.22	100%
8	Салбарын спортын тэмцээнд оролцох ажлыг зохион байгуулах	БОУАӨЯ-ны харьяа байгууллагуудын тэмцээн 2025 оны 9 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулагдах тэмцээнд газрын албан хаагчдаас дэмжлэг хүсэж бооцооны болон заал, хоол, ундааны мөнгийг бүрдүүлж өгсөн.	IX.22	100%
9	Дархан-Уул, Дорнод аймгийн УЦУОШТөвд албан томилолтоор ажиллахад төвийн албан хаагчдын тавьсан хүсэлтийг судалж, танилцуулах	Дархан-Уул аймаг дахь ХААИС-ийн цаг уурын тэнхимтэй холбогдож УМХэлтэс. НЦУТ дээр эхний ээлжид 4 дүгээр ангийн 2-3 оюутан, аймгийн УЦУОШТөв дээр 15 оюутныг мэргэжлийн дадлага хийлгэхээр ярилцсан. Мэргэжлийн зөвлөлийн багш нартайгаа хуралдаад эргээд холбогдохоор тохиролцсон. МУИС-ийн Дорнод аймаг дахь салбар сургуулийн цаг уурын тэнхим нь одоогоор цаг уурын төв дээрээ ажиллаж буй 4 албан хаагч сурч байгаа учраас мэргэжлийн дадлага шаардлагагүй гэсэн хариу өгсөн.	IX.22	100%
10	Хэвийн бус нөхцөлд ажилладаг БОШлабораторийн технологич инженерүүдийн албан тушаалын нэршлийг ЯАМАТ-ын кодтой уялдуулах	Хэвийн бус нөхцөлд ажилладаг БОШлабораторийн технологич инженерүүдийн албан тушаалын нэршлийг ЯАМАТ-ын кодтой уялдуулахаар яам руу шинэчилсэн тогтоолын төсөл хүргүүлсэн.	IX.22	100%
11	Дорнод аймгийн УЦУОШТөвийн БОШЛаборатори нь Улсын тэргүүний лабораториор шалгаран шагнуулсан боловч өнөөдрийг хүртэл албан хаагчид шагналын урамшууллаа аваагүй тухай судалж танилцуулах	Тус асуудлаар судалж, газрын даргад танилцуулж, төвийн даргаас нь мэдээлэл авч, шийдвэрлэсэн. Төвийн дарга нь 2 ажилтны урамшуулал олгох боломжтой гэсэн ба 1 ажилтан нь ажлаасаа гарсан гэсэн.	IX.22	100%
12	ЦАЗН-ийн инженерүүдийн ажлын байр 0.5-аар батлагдсантай холбогдуулан ХАБ-ын чиг үүргийг хариуцаж	ЦАЗН-ийн инженерүүдийн ажлын байр 0.5 дээр МСДСЗохицуулагч инженерийг 0.5 аар төдийн бүтэц орон тоо батлагдсан. ХАБ-ын чиг	IX.22	100%

	ажиллах боломжгүй нөхцөл байдал үүссэн талаар судалж, танилцуулах	үүргийг өөр албан тушаал дээр болон төвийн дарга өөрөө ч хариуцан хийж болох юм.		
13	Харьяа байгууллагын дарга захиралуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтаны чиг үүргийг хавсран гүйцэтгүүлж, нэмэгдэл олох тушаал батлуулах	2025 оны 10 дугаар сарын 6-ны А/214, 10 дугаар сарын А/219, А/220, А/221 тоот тушаалуудаар харьяа байгууллагын дарга захиралуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтаны чиг үүргийг хавсран гүйцэтгүүлэх 40 хувийн нэмэгдэл олгох тушаал боловсруулж батлуулсан. 12 дугаар сарын 11-ны өдөр ажил олгогчийн сургалт зохион байгуулна.	X.06	100%
14	Албан хаагчдын англи хэлний мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, албан хаагчдын сургалт, хөгжлийн шийдлийн санал танилцуулах	Албан хаагчдын англи хэлний мэдлэг, чадварыг дээшлүүлэх талаар албан хаагчдаас санал авч зохион байгуулна.	X.06	100%
15	Төрийн албан хэрэг хөтлөлтийг кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулах тухай Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албанаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу Ажлын төлөвлөгөө батлуулах, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах	2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр төрийн албан хэрэг хөтлөлтийг кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулах тухай хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албанаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган газрын даргаар батлуулсан.	X.06	100%
16	2025 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн "Бүх нийтийн мод тарих өдөр" арга хэмжээнд оролцох ажлыг зохион байгуулах	2025 оны 10 дугаар сарын 11-ний өдөр болох "Бүх нийтийн мод тарих өдөр" арга хэмжээг Тэрэлжид зохион байгуулах ба нийт 49 албан хаагчид оролцсон.	X.06	100%
17	Өртөө, харуулын газрын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор газар эзэмших эрхийн гэрчилгээг сунгах, мөн үнэ төлбөргүйгээр газар ашиглах эрхтэй холбоотой эрх зүйн боломж, гарц, шийдлийг судалж, танилцуулах.	Сүхбаатар аймгийн газрын гэрчилгээний хугацаа дууссан асуудал нь хууль зүйн хувьд зөрчлөө арилгаж, торгуулиа төлж, сунгуулахаас өөр боломж байхгүй. ЗГ-н тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд байгаа гэрчилгээг хугацаатай олгосон, хугацаа дуусахаасаа өмнө сунгуулах үүрэг нь эзэмшигч байна. Зөвшөөрөлгүй газарт үйл ажиллагаа явуулсан гэж 5 000 000 төгрөгөөр торгуулах тавигдсан байгаа нь газрыг эзэмших эрх нь дуусаад, сунгуулаагүй учир, зөвшөөрөлгүй газар эзэмшигч ашиглагч болж байна гэсэн. Үүнд төр хувийн хэвшил хугацаа сунгуулахад тэгш эрхтэй, төвийн дарга нь холбогдох хүмүүст албан тоотой хандаад, асуудлаа шийдүүлэх талаар газрын даргад мэдээлэл өгсөн, мөн төвийн даргад мөн энэ талаар тайлбар өгсөн.	X.06	100%

18	Архивын улсын үзлэгийн хүрээнд байгууллагын дотоод үзлэгийг зохион байгуулж, албан хаагчдад мэргэжил, арга зүйн зөвлөмж өгөх	Архивын улсын үзлэгийн хүрээнд байгууллагын дотоод үзлэгийг зохион байгуулж, албан хаагчдад мэргэжил, арга зүйн зөвлөмж өгч ажилласан. ЦУОШГ-ын албан хаагчид болон Харьяа байгууллагуудад сургалтыг Цахимаар зохион байгуулсан.	XI	100%
19	Яамны нүүлгэлттэй холбоотойгоор суларсан өрөө, тасалгааг байгууллагын хэрэгцээ, зориулалтад нийцүүлэн хувиарлах	3 давхрын суларсан 303 өрөөнд сайдын зөвлөх, 308 өрөөнд Мазаалай төсөл, 306 өрөөнд Гадаргын усны судалгааны хэлтсийн албан хаагчид, 309 өрөөнд Сургалтын танхим, 302 өрөөнд Мэдээллийн технологи, сүлжээний хэлтсийн албан хаагчид орж хаягжуулсан. 311, 313 тоот өрөөнд СВIT2 төсөл орно. /засвар хийж орохоор ярьсан/.	XI	100%
20	Яамны нүүлгэлттэй холбоотойгоор үүдний хэсэг болон хурлын заалны хаягийг шинэчлэх	Үүдний хэсгийг хуулж цэвэрлэсэн бгаа хуучин үсэг наах гэхээр зарим нь хагарсан зарим нь наах боломжгүй байгаа тул санхүү төсөв хүлээгдэж байна.	XI	100%
21	Албан тушаалын тодорхойлолт шинэчилж, батлуулах	Төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулсан.	XI	100%
22	Оны төгсгөлд тайлан, мэдээ өгөх оруулах, хариуцсан ажлуудаа цэгцлэх, хяналт тавих	Төвийн дарга нарт тайлангаа 12 дугаар сарын 10-ны дотор ирүүлэх албан тоот хүргүүлсэн. Газрын албан хаагчид 5-дотор, газрын даргын 2025 оны тайланг 2-ны дотор хүргүүлэхээр өдрүүдийг товлосон байгаа.	XI	100%
23	Харьяа байгууллагын удирдлагууд, зөвлөхүүдийн өрөө гаргах	Хуучин байрны 2 давхарын 218 дугаар өрөөг бэлдсэн.	XI	100%
24	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" цахим сургалт, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэстэй хамтран "Мэдэгдэл, тайлбарыг ямар үед гаргах, хамаарал бүхий этгээддээ захиргааны шийдвэр гаргасан тохиолдолд хуулийн ямар арга хэмжээ авагдах вэ" сэдэвт цахим сургалтуудыг зохион байгуулж салбарын албан хаагчдаа хамруулсан. Мөн байгууллагын "Авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөө", "Авлигатай тэмцэхэд олон нийтийн оролцоог хангах нь" төлөвлөгөөг батлуулан тусгагдсан үйл ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	XI	100%


25	Хүйтний улирал эхэлсэнтэй холбоотойгоор гадна талбайд халтиргаа, гулгаа үүсэхээс урьдчилан сэргийлж цэвэрлэгээ, үйлчилгээнд анхаарах	Цас орсон тохиолдолд үйлчлэгч нар тухай бүр гарч цэвэрлэгээг тогтмол хийж байна.	XI	100%
----	--	--	----	------

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Монгол бичиг /анхан шат/	-	-	-	УА-ын цахим сургалтад хамрагдаж сертификат авсан. /хавсаргав/	11 сард	100
2.	Арга хэмжээ 2. Жендерийн мэдрэмжтэй харилцаа холбоо	-	-	-	УА-ын цахим сургалтад хамрагдаж сертификат авсан. /хавсаргав/	12 сард	100

ТАЙЛАН БИЧСЭН:
Архив, мэдээллийн сангийн хэлтсийн дарга

Р.Бадмаадорж / /
(Нэр, гарын үсэг)



2025.12.15 (Огноо)



УДИРЛААГЫН
АКАДЕМИ



In partnership with

Canada



MERIT
catalyst

ҮНЭМЛЭХ

№:735335

Раднаасүмбэрэловогтой Бадмаадорж

Жендерийн мэдрэмжтэй харилцаа холбоо

ЦАХИМ СУРГАЛТАД АМЖИЛТТАЙ ХАМРАГДСАН ТУЛ ЭНЭХҮҮ
ҮНЭМЛЭХИЙГ ОЛГОВ.

Д.СҮРЭНЧИМЭГ

Удирдлагын академийн
захирал

ЖЕННИФЕР АДАМС

"Каталист Плас" байгууллагын олон улсын
хамтын ажиллагаа хариуцсан захирал

2025.12





УДИРДЛАГЫН
АКАДЕМИ

ҮНЭМЛЭХ

№ 757418

Раднаасүмбэрэвогтой БАДМААДОРЖ

“Монгол бичиг” анхан шат

ЦАХИМ СУРГАЛТАД АМЖИЛТТАЙ ХАМРАГДСАН ТУЛ ЭНЭХҮҮ
ҮНЭМЛЭХИЙГ ОЛГОВ.

Д. БАЙГАЛ

Доктор, профессор
Удирдлагын академийн
захирал

Ж. ЖАРГАЛ

Доктор, дэд профессор
Удирдлагын академийн
Төрийн албаны сургуулийн захирал



2025

**ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Р.БАДМААДОРЖИЙН
2025 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Цаг уур, орчны шинжилгээний газар

Нэгжийн нэр: Захиргаа, хүний нөөцийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	96.8	69.4 66.7

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Арга хэмжээ 1. Монгол бичиг /анхан шат/ сертификаттай	100	15
2.	Арга хэмжээ 2. Жендерийн мэдрэмжтэй харилцаа холбоо сертификаттай	100	15
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			15 13

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	
2.	Удирдан зохион байгуулах	
3.	Асуудал шийдвэрлэх	
4.	Манлайлах	
5.	Багаар ажиллах	
6.	Харилцаа	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7.	Мэргэжлийн ур чадвар 1.	
8.	Мэргэжлийн ур чадвар 2.	
9.	Мэргэжлийн ур чадвар 3.	
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		10

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)	69.4 66.7
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ	10

	(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		87.5

Үнэлгээ өгсөн:

Төсвийн шууд захирагч

Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга

/...../ Э.Баттулга



(огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Нэгжийн дарга:

Архив, мэдээллийн сангийн хэлтсийн дарга

/...../ Р.Бадмаадорж

(огноо)